

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС**

“Тогтоол шийдвэрийн хяналтад авсан
заалтын 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн тухай”

2025 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг үндэслэл болгов.

Хяналт-шинжилгээний зорилго нь дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт нь үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, явцын үнэлгээ хийж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын “Үнэлгээ хийх” журмын 3.2-т заасны дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/223 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Үнэлгээний багийг байгуулан ажилласан.

Үнэлгээний багийн даргаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга С.Туулмаа, гишүүд дүүргийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч Д.Сүхбаатар, Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Норовдэмид, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Янжинлхам, мэргэжилтэн Б.Мөнхзул, Ш.Оюун-Эрдэнэ, Л.Оюундарь нар ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын 3.7-д заасан аргачлалыг хэрэглэв.

Хэрэгжсэн заалтын тоо

Хууль тогтоомж тогтоол = _____ х 100%
шийдвэрийн хэрэгжилтийн дүн (Нийт заалтын тоо – Хугацаа болоогүй заалтын тоо)

2025 онд Монгол Улсын Хууль-2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар-4, Засгийн газраас гарсан шийдвэр-2 нийт 8 тогтоол, шийдвэрийн 19 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ажиллалаа.

Тогтоол шийдвэрийн нэр	Тогтоол, шийдвэрүүд	Монгол Улсын Хууль	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газраас гарсан шийдвэр
Хяналтад авсан шийдвэрийн тоо	8	2	4	2
Хяналтад авсан нийт заалтын тоо	19	7	6	6

Үүнээс	Хэрэгжсэн заалт	16	6	5	5
	Хэрэгжээгүй заалт	3	1	1	1
	Хугацаа нь болоогүй заалтын тоо	0	0	0	-
Үүнээс	Тасарсан	-	-	-	-
	Зохион байгуулалтаас	-	-	-	-
	Хөрөнгө дутагдсанаас	-	-	-	-
	Биелэлтийн дүн /хувь/	80,9%	85,7%	83,3%	83.3%

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж

1. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлэх, хариуцсан нэгжийн дарга нар биелэлтийг сайтар хянаж, нотлох баримттай, товч тодорхой тоо баримттай тайлагнах

2. Тогтоол, шийдвэрүүдэд тусгагдсан заалтуудаас үнэлэх боломжгүй, зорилго нь тодорхойгүй, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан ажлуудад дүгнэлт хийж, баримтаар нотолж, удирдлагууд болон холбогдох дээд шатны байгууллагад цаг алдалгүй мэдээлж байх

3. Хэлтэс, тасгийн дарга нар ажил хариуцсан албан хаагчдын баримт бичиг боловсруулах, тайлагнах, мэдээлэх чадавхыг сайжруулахад анхаарах.

4. Биелэлт гаргахдаа товч тодорхой, үр дүнг тооцсон, тоо баримтыг нэгдсэн байдлаар гаргаж, арга хэмжээг хэмжих, үнэлэх үндэслэл бүхий байхаар гаргаж байхыг зөвлөж байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА *М.Уулмаа* С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *О. Янжинлхам* О.ЯНЖИНЛХАМ

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 09			Улаанбаатар хот					
Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл заалтын агуулга	Хэрэгжилтын тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээ эгүй шалтгаан	Хяналтаа с хасах үндэслэл	Хяналт- шинжилгээ, үнэлгээний үнэлгээ
1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	3	4	5	6	7	8	9
МУ-ын хууль								
1		19.1.1	.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл өсч байгаа хороодод гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, бэлэн байдлыг ханган зөөврийн "Пост" байршуулж ажиллаж байна. Гэмт хэргийг буруулах ажлын хүрээнд "Аюулгүй орчин" аян зарлаж урьдчилан сэргийлэх ажлыг 5 чиглэлээр зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага иргэн аж ахуйн нэгжид шаарлага-112, зөвлөмж-78 өгч үр дүнг тооцож, шаардлага биелүүлээгүй 4 иргэн, 3 албан тушаалтныг нийт 5.3 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Теле камерын хяналтын дэд төв" 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус төвд өнөөдрийн байдлаар дүүргийн Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтсээс тус бүр нэг албан хаагч 24 цагаар ажиллаж байгаа бол Нийслэлийн мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс нэг ажилтан дуудлага, мэдээллийг тухай бүр шууд хүлээн авч, холбогдох байгууллагад цаг	100			Хэрэгжсэн

2024-06-05 Дугаар 2024_72 207 279 470		байгууллагын бүтэц, орон тоог чиг үүрэг нь шилжиж байгаа хотод хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх. (Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)				
1.2	1.1-Д заасан дүүргүүдийн "Теле камерын хяналтын дэд төв"-ийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах "Теле камерын хяналтын төв"-ийг нэгдсэн холбогдох хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарг;	Энэ тогтоолын 1.1-Д заасан дүүргүүдийн "Теле камерын хяналтын дэд төв"-ийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах "Теле камерын хяналтын төв"-ийг нэгдсэн холбогдох хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарг;	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Теле камерын хяналтын дэд төв" 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус төвд өнөөдрийн байдлаар дүүргийн Цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтсээс тус бүр нэг албан хаагч 24 цагаар ажиллаж байгаа бол Нийслэлийн мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс нэг ажилтан дуудлага, мэдээллийг тухай бүр шууд хүлээн авч, холбогдох байгууллагад цаг алдалгүй мэдэгдэн ажиллаж байна. "Теле камерын хяналтын дэд төв"-д нийт 165 ширхэг камер бүртгэлтэй байгаагаас хэвийн ажиллагаатай 133 ширхэг камер байна. Камерын хяналт бүхий "Ногоон бүс" байгуулах ажлын хүрээнд дүүргийн 12, 18, 33 дугаар хороодыг камержуулах ажлын зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.	100		Хэрэгжсэн
2.10	... энэ тогтоолын хавсралтаар заасан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг аймаг,	Энэ тогтоолын хавсралтаар заасан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг аймаг,	2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд дүүргийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 90 тн өвс, 20 тн тэжээл бүрдүүлсэн. Дүүргийн малтай 21, 32-р хорооны 572 өрхөд өвс, тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлсэн. 2025 оны 8-р сарын байдлаар дүүргийн аюулгүй нөөцөд 20 тн тэжээл бэлтгэсэн. Нэмж 30тн тэжээлийг "Милл хаус" ХХК-аас авахаар гэрээ хийсэн.	100		Хэрэгжсэн

<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар</p>	<p>Хэрэгжсэн</p>
<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 "Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар, "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар, "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгаврын хүрээнд:</p>
<p>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу ЗДТГ-ын холбогдох 164 мэдээллийг улирал бүр shien.gov.mn сайтад оруулж ил тод, нээлттэй байдлыг хангасан. Мөн байгууллагын цахим хуудсанд иргэдийн өргөдөл томдлыг хүлээн авах талбар үүсгэж, 70173317 тусгай дугаарын утас ажиллуулж иргэдийн санал хүсэлт өгөх асуудлыг хялбарчилсан.</p> <p>- "Авлигын эсрэг нэгдье" 1 сарын аяныг дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 23 байгууллагуудын дунд 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж авлигыг үл тэвчих хандлагыг төлөвшүүлж, урьдчилан сэргийлэх ажлуудыг байгууллага бүр зохион байгуулж ажиллалаа.</p> <p>- Дүүргийн хэмжээнд "Хурдан цэг"-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 18 хороонд "Хурдан цэг" нэмж байгуулсан бөгөөд 384.0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг дүүргийн 43 хороонд угсарч суурилуулсан. Төрийн үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 43 хорооны "Хурдан цэг"-ийн үйл ажиллагааг хянаж, 32 хороонд 43 байгууллагын 453 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Толгойт, Тахилт, Баруун салаа, Содон хороолол зэрэг алслагдсан болон хүн ам шигүү суурьшсан байршилд хөдөлгөөнт "Хурдан цэг"-ийг түр хугацаанд байршуулж, төрийн үйлчилгээг</p>	
<p>1</p>	<p>100</p>

	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар албан даалгавар</p>		<p>"Төрийн албаны сахилга, журам, хариуцлагыг чангатгах тухай"</p>	<p>иргэдэд хүргэж ажилласан. "E-MONGOLIA" портал сүлжээний хэрэглээг олон нийтэд сурталчилах чиглэлээр мэдээ танилцуулга бэлтгэж дүүргийн сайтаар тогтмол түгээж байна.</p> <p>Төрийн зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр "Улаанбаатар шинэчлэл" ХХК, "Охь мандал" ХХК, "Хүннү билэг" ХХК, "Аливаа гоулд" ХХК, "Эко эрин тохижилт" ХХК, "Мэйжик тайм" ХХК-иудаар гэрээний дагуу хог тээвэрлэх ажлыг гүйцэтгүүлж байна. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний ажилд "Грейт роуд" ХХК, "Улаанбаатар шинэчлэл" ХХК, "Охь мандал" ХХК, "Би ти эс эм" ХХК, "Зэлтэр бэйс" ХХК тендерт шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 98821 кв талбайн ногоон байгууламжийн цэцэгжүүлэлт, хэлбэржүүлэлт, усалгаа, арчилгаа, нөхөн тарилтыг Хос халиун пропертис ХХК, Голден гарден ХХК, Ойн таксацн ХХК, Нүри ХХК гэсэн 4 компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.</p> <p>-Төрийн албаны мерит зарчмын хүрээнд анхан шатны нэгж хороонд ажиллаж байсан 5 албан хаагчийг шатлан дэвшүүлж Тамгын газарт томилсон. Тамгын газраас дээд шатны байгууллага руу 4 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан байна. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилсон, чөлөөлсөн шийдвэр гараагүй.</p> <p>- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлагыг төлөвшүүлэх, авлига,</p>	<p>100</p>		<p>Хэрэгжсэн</p>
--	---	--	--	---	------------	--	------------------

	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хүрээнд:</p>		<p>“Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”</p>	<p>албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлье” нэгдсэн сургалтыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр захиргааны байгууллагуудын удирдах, гүйцэтгэх 650 гаруй албан хаагчдыг хамруулж зохион байгуулсан. Мөн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 6 байгууллага урьдчилан сэргийлэх сургалтыг байгууллагдаа зохион байгуулж 300 албан хаагчийг хамруулсан байна. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх 12 төрлийн постер, хууль тогтоомжийг таниулах чиглэлээр 2 удаагийн богино бичлэгийг бэлтгэн олон сувгаар төрийн албан хаагч, иргэд олон нийтэд түгээн ажилласан. Дүүргийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын Тамгын газар, хороодын зохион байгуулалт бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/179 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газарт улс төрийн 5, төрийн захиргааны 65, төрийн тусгай 7, төрийн үйлчилгээний 81, нийт 158 орон тоотой, Хороодод улс төрийн 43, төрийн захиргааны 93, төрийн үйлчилгээний 90, нийт 226 орон тоотой, нийт Тамгын газар, хороодод 384 орон тоотой байхаар бүтэц, орон тоог баталсан. Тамгын газарт төрийн захиргааны 72 албан хаагч ажиллахаас 56 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 5 орон тоонд томилгоо хийгээгүй, 11 сул орон тоонд хавсран гүйцэтгүүлж байна./Мүнээс удирдах</p>	<p>100</p>		<p>Хэрэгжсэн</p>
--	---	--	---	---	------------	--	------------------

4	1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган Сонгинохайрхан дүүргийн 2025 онд зарцуулахаар төлөвлөсөн хангамж, бараа материалын зардалд 19,169.4 сая төгрөг зарцуулахаас 17,295.6 сая төгрөг, Гадаад, дотоод томилолтын зардалд 179.5 сая төгрөг батлагдсанаас 165.7 сая төгрөгийг тус зарцуулан хэрэгцээгүй худалдан авалтыг тэвчиж 1,887.6 сая төгрөгийг хэмнэлт үүсгэн ажилласан болно. 2025 онд нийт 30 удаагийн сургалт зохион байгуулж танхимаар 12, цахимаар 18 удаагийн сургалтыг зохион байгуулан ажилласан болно.	Уүрэг даалгаврын хүрээнд байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхэд өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг харгалзан үзэж үр дүнг тооцон ажиллаж байна.	100	СХД			Хэрэгжсэн	83,3%
Нийт дундаж хувь 100%										

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАРСАН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл заалтын агуулга	Хэрэгжилтын тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлгээ
1	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан	3	4	5	6	7	8	9
1	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан	дугаар 2025_03	1.8. Бус, орон нутгийн онцлолт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төсөл"-ийг 2025-2028 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 33 дугаар тогтоолоор батлуулан,	100			Хэрэгжсэн

2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-03-07	хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;	2025 онд 3 зорилт, 14 арга хэмжээтэйгээр төлөвлөн, хэрэгжүүлж байна. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "АЖИЛ ОЛГОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН 2025" арга хэмжээг зохион байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил-Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт" уриан дор зохион байгуулж, 3 удаагийн танхимын сургалтаар 500 гаруй албан хаагчдыг чадавхжуулж, 66 ААНБ-д хяналт хийн, зөвлөмж хүргүүлэн ажилласан.				Хэрэгжсэн
	1.9. Бүс, орон нутагт шилжин суурьшиж буй өрх, иргэн, бизнесийн салбараа нээж буй аж ахуйн нэгжийг дэмжих төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;	Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, худалдан борлуулах үйлчилгээний борлуулалтын цэгийг 3 байршилд шинээр нээлээ. Дүүргийн 29 дүгээр хороонд байрлах Шинэ Драгон терминал төвийн В1 давхарт 48 м2 талбайд 7 иргэн, 1 дүгээр давхарт 35 м2 талбайд 15 иргэнийг хамруулаад байна.	Мөн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Соёолж малл худалдааны төвийн 6 давхарт 28 м2 талбайд 6 үйлдвэр эрхлэгчийг хамруулан, байнгын борлуулалтын цэгийг 3 байршилд шинээр бий болгож, нийт 28 иргэнд дэмжлэг	100		

		<p>дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх;</p>	<p>эрхлэлтийн сургалт, туршлага судлах арга хэмжээнд 35 иргэн, захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх 18 удаагийн сургалтад танхимаар 365 иргэн, нийт 786 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулсан.</p> <p>Мөн тайлант хугацаанд дараах сургалтуудыг явуулж, иргэд аж ахуйн нэгжүүдийг мэргэшүүлсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хэрхэн маркетер шиг сэтгэх вэ • Брэнд хэрхэн бүтээх вэ • Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хурдасгуур хөтөлбөр • Мэргэжлийн нэгдсэн холбоо түүний эрх зүйн байдал • Татварын шинэчлэл хувийн хэвшлийн оролцоо • Хүлэмжийн аж ахуй • Геометрийн прогрессоор хурдацтай хөгжиж буй мөөгний инноваци • Бизнес төсөл боловсруулах • Бизнесээ албан ёсоор эхлүүлэе • Борлуулалтын хүч-1,2 • Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ • Гар урлал, оёдол эсгүүрийн сургалт • Албан бус салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль, эрх зүйн зохицуулалт <p>Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Азийн хөгжлийн банк, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс хэрэгжүүлж буй</p>			
--	--	--	---	--	--	--

			<p>“Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-т зорилтот бүлгийн 716 өрх хамрагдсан бөгөөд 303 өрх үйлдвэрлэл эрхэлж байна. Эдгээр өрхүүдийг бизнесээ хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ брэнджүүлэх сургалтад хамруулан ажлын байраар хангаж байна.</p> <p>“Сар шинэ 2025” үзэсгэлэн худалдаанд цагаан идээ, гар урлал, ноос ноолууран бүтээгдэхүүн, эсгий урлал, үндэсний хувцас зэрэг бүтээгдэхүүнээр 35 өрх хамрагдан борлуулалтын орлогоо нэмэгдүүлсэн. Мөн 3 байршилд байнгын борлуулалтын цэгийг шинээр бий болгож, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулж байна. Мөн Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвүүдээр дамжуулан чөдавхжуулах сургалтуудыг зохион байгуулж байна.</p>			
469	1.12. Зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх;	Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Азийн хөгжлийн банк, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-т зорилтот бүлгийн 716 өрх хамрагдсан бөгөөд 303 өрх үйлдвэрлэл эрхэлж байна. Эдгээр өрхүүдийг бизнесээ хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ брэнджүүлэх сургалтад хамруулан ажлын байраар хангаж байна. “Сар шинэ 2025” үзэсгэлэн худалдаанд цагаан идээ, гар урлал, ноос ноолууран бүтээгдэхүүн, эсгий	100			Хэрэгжсэн

2	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон	Дугаар 2025_03	1.24. 1.24. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;	<p>урлал, үндэсний хувцас зэрэг бүтээгдэхүүнээр 35 өрх хамрагдан борлуулалтын орлогоо нэмэгдүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас гэр бүлийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "Нээлттэй өдөрлөг"-т Төгсөлтийн аргачлал хөтөлбөрт хамрагдсан 60 иргэнийг үзэсгэлэн худалдаанд оролцуулж, борлуулалтын дэмжлэг үзүүлсэн. "Холт" олон улсын байгууллага нь амьжиргааны түвшин доогуур хөгжлийн бэрхшээлтэй 260 хүүхдэд 55,3 сая төгрөг, 4 өрхөд иж бүрэн гэрийн дэмжлэг, "Эрдэм өргөө" номын сангаар дамжуулан, дүүргийн 9, 62, 143, 65, 12 дугаар сургуулиудын 1-12 ангийн сурагчид тав тухтай орчинд хичээлээ хийх, ном унших, интернет ашиглах зэрэг үйлчилгээ авч байна. Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Монголчууд монголчууддаа хөтөлбөрийн хүрээнд өөрийн гэсэн орон гэргүй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настантай 10 өрхөд иж бүрэн 5 ханатай гэр гардууллаа.</p> <p>Нийслэлийн Аялал жуулчлалын газарт дүүргийн Засаг даргын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 29 дүгээр хорооны нутаг дэвсгэр хуучнаар Сүлжмэлийн үйлдвэрийн урд байршилтай 4600 метр квадрат ТҮЦ нүүлгэсэн талбайд Худалдаа, үйлчилгээ,</p>	100		Хэрэгжээгүй
---	--	----------------	---	--	-----	--	-------------

	<p>нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-03-07</p>	<p>(2.17. худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж явууллын үйлчилгээ бий болгож тохижилт гудамжийг нийслэл Улаанбаатар хотын дүүрэг бүрд байгуулахыг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт)</p>	<p>аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж явууллын үйлчилгээ бий болгож тохижилт хийлгэх ажлын саналыг дүүргийн Засаг даргын 2025.04.08-ны өдрийн 01/982 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.</p> <p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр "Монгол хүүхдүүд-2025" өсвөр насны хүүхдүүдэд зориулсан урлаг соёлын арга хэмжээг Хүүхэд залуучуудын театрын гадна талбайд дүүргийн хэлтэс албадуудтай хамтран зохион байгуулсан. Баярын арга хэмжээнд зориулж street food-10, хүүхдийн тоглоом, бэлэг, ус ундааны худалдаа-16 нийт 26 худалдаа үйлчилгээг гарган гудамж байгуулж иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.</p>			
<p>Нийт дундаж хувь 100%</p> <p style="text-align: right;">83,3%</p>						

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСИЙН ДАРГА

М.Сүх

С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *О. Амтшан* О.ЯНЖИНЛХАМ